

International Theatre Institute ITI

World Organization for the Performing Arts



Дэлхийн театрын өдөр 2021 – 3 дугаар сарын 27

Хелен МИРРЕН-ий намтар, ИБУИНВУ

Тайз, дэлгэц, телевизийн жүжигчин

Монгол (орчуулга)

Хелен МИРРЕН

Тайз, дэлгэц, телевизийн жүжигчин

Хелен Миррен бол олон улсын хэмжээний олны хүндэтгэлийг хүлээсэн жүжигчин ба тэрээр тайз, дэлгэц болон телевизийн өргөн хүрээний, хүчирхэг бүтээлүүдээрээ олон шагналтай ба 2007 оны Академийн шилдэг эмэгтэй гол дүрийн шагналыг “Хатан хаан”-ы дүрээрээ хүртсэн.

Театр

Хелен Миррен жүжигчний гараагаа Залуучуудын Үндэсний Театрт Клеопатрагийн дүрийг бүтээснээр эхлүүлжээ. Тэрээр дараа нь Манчестерт ажиллаж байгаад Роял Шекспьерын компани (РШК)-д ажиллах болов. РШК-д гайхамшигтай дөрвөн жилийг өнгөрүүлсний дараа тэрээр нэрт найруулагч Петер Брукын театр компани Центр де Решерше Театралд ажиллан африк, америкаар аялан тогложээ.

Үүнээс хойш Вэст Энд, Фринж, РШК, Үндэсний театр болон АНУ-ын Бродвэйн театр гээд маш олон театрт гайхалтай бүтээлүүдэд дүр бүтээсэн ба *Хөдөө өнгөрүүлсэн нэг сар* бүтээлээрээ Тони шагналд, Бродвэйн *Үхлийн бүжиг* бүтээлээрээ Айэн МакКеллантай өрсөлдөн нэр дэвшиж байжээ.

Донмар Ворхаусын бүтээл *Жаргаж буй Орфус* болон Үндэсний театрын бүтээл *Гашуудсан Электра-д тоглосон* дүрээрээ Оливиерын Шилдэг Жүжигчний шагналд тэрээр нэр дэвшиж байв.

Тэрээр 2009 онд Үндэсний театрт эргэн ирж Николас Хайтнерын найруулсан *Федре* бүтээлд Расины дүрийг бүтээсэн ба уг бүтээл нь NTLive-д бичигдэн дэлхий даяар кино театруудад гаргасан театрын анхны бүтээл болон түүхэнд тэмдэглэгджээ.

Сүүлд тэрээр Лондонгийн Вэст Энд театрт 2013 онд Стефен Далдрийн найруулсан Петер Морганы *Үзэгчид* бүтээлийн хоёрдугаар Элизабет хатан хааны дүрийг бүтээв.

Тэрээр Оливиер Шагнал ба Тайзан дээр Юу байна нэртэй шилдэг эмэгтэй жүжигчний шагналуудыг хүртсэн аж. *Үзэгчид* бүтээлийг 2015 оны 2-р сард Нью Йорк дахь Жералд Шёнфелд театрт шилжүүлэхэд Хелен Мирренийг гол дүрийн жүжигчнээр хамтад нь явуулсан ба уг дүрээрээ тэр шилдэг эмэгтэй жүжигчнээр шалгарч Тони авардс шагналыг хүртсэн байна.

Кино, телевиз

Тайзан дээр дүр бүтээхээс гадна Хелен Миррен дэлгэц, телевизийн бүтээлүүдэд гайхамшигтай амжилт гарган нэр алдарт хүрсэн жүжигчин юм.

Хелен Миррен 2003 онд Британийн эзэнт улсын эрхэмсэг хатагтай хэргэм хүртжээ.

Тайз, дэлгэц, телевизийн салбар дахь түүний бүтээлүүдийн талаар болон түүний сэтгэл зүрхээ зориулдаг сайн үйлсийн аян болон амьдралынх нь талаар илүү дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл [**www.helenmirren.com**](http://www.helenmirren.com) хаягаар зочилно уу.